



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ОЮУТНУУДЫГ АВСТРАЛИ УЛСЫН ФЛИНДЕРСИЙН ИХ СУРГУУЛЬД СУРАЛЦУУЛАХ СУРГАЛТЫН ТЭТГЭЛЭГ ОЛГОХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны сайд, Австрали Улсын Флиндерсийн Их Сургууль хоорондын байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газар болон Флиндерсийн Их Сургуультай орон нутгийн иргэдийг тэтгэлэгт хөтөлбөрөөр суралцуулах санамж бичгийг 2024 онд байгуулсан.

1.2. Өмнөговь аймгийн иргэдийг шилдэг, чанартай боловсрол эзэмших, тэгш боломжоор бүрэн хангаж, орон нутгийнхаа хөгжилд хувь нэмрээ оруулах, эх оронч сэтгэлтэй, зөв хандлагатай, олон улсад өрсөлдөх чадвартай, бүтээлч, манлайлагч хүний нөөцийг бэлтгэхэд тэтгэлгийн ач холбогдол орших юм.

1.3. Тэтгэлгээр суралцуулах мэргэжлийн жагсаалтыг Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол, шинжлэх ухааны газраас хамтран аймгийн хөгжлийн бодлого, орон нутагт хэрэгцээтэй мэргэжлүүдтэй уялдуулан гаргана.

1.4. Тэтгэлэг олгох үйл ажиллагаа нь ил тод, нээлттэй, шударга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, орон нутагтаа 3-аас доошгүй жил ажиллаж амьдарч байгаа Өмнөговь аймгийн иргэн бүрт тэгш боломжийг олгоно.

1.5. Тэтгэлгийг энэ журамд заасан шаардлагыг хангасан, сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэнд олгоно.

Хоёр.Тэтгэлгийн төрөл

2.1. Тэтгэлэг нь дараах төрөлтэй байна:

2.1.1. Орон нутагт хэрэгцээтэй мэргэжлээр бакалавр, магистр, докторын сургалтын хөтөлбөрт хамруулах

2.1.2. Англи хэлний багш нарыг богино хугацааны чадавхжуулах сургалтад хамруулах

2.1.3. Төрийн албан хаагчдыг богино хугацааны чадавхжуулах сургалтад хамруулах



Гурав.Тэтгэлгийн сонгон шалгаруулалтын үе шат, шаардлага

3.1 Магистр, бакалавр, богино хугацааны сургалтын хөтөлбөрөөр суралцуулах мэргэжлийн чиглэлийг аймгийн Засаг даргын Тамгын газраас жил бүр хөгжлийн жилийн төлөвлөгөө, хүний нөөцийн мэдээллийн санд тулгуурлан шинэчилнэ.

3.2 Тэтгэлэгт хамрагдах мэргэжлийн чиглэл, сонгон шалгаруулах хугацаа зэргийг аймгийн Засаг даргын Тамгын газраас боловсруулан олон нийтэд нээлттэй зарлана.

3.3 Өмнөговь аймгийн 15 сумын хэмжээнд тэтгэлэгт хөтөлбөр зарлагдах бөгөөд дараах шалгуур хангасан иргэн материалаа бүрдүүлж цахимаар бүртгүүлж, зорилгоо тодорхойлсон 1500 үгтэй эссэ бичнэ.

3.3.1. Магистр, докторын хөтөлбөрөөр суралцах хүсэлтэй иргэн, төрийн албан хаагч нь дараах шаардлагыг хангасан байна

3.3.1.1 сүүлийн 3-аас доошгүй жил орон нутагтаа тогтвор суурьшилтай ажилласан,

3.3.1.2 суралцахыг хүссэн мэргэжилтэй хамаарал бүхий баклавар, түүнээс дээш мэргэжлийн зэрэгтэй байх,

3.3.1.3 магистрт суралцах бол баклаварын голч оноо 3.0 ба түүнээс дээш байх,

3.3.1.4 докторт суралцахад Флиндерсийн Их Сургуулийн докторт суралцах холбогдох шаардлагыг хангасан байх.

3.3.1.5 харьяалах удирдлага болон ажил, мэргэжлийн хувьд суралцах чадвартайг нотолж дэмжсэн тодорхойлолтыг ирүүлэх.

3.3.2. Баклаварын хөтөлбөрөөр суралцах хүсэлтэй иргэд дараах шаардлагыг хангасан байна

3.3.2.1 Өмнөговь аймгийн ерөнхий боловсролын сургуулийн хамран сургах тойргийн дагуу харьяалах суманд суралцан төгссөн байна;

3.3.2.2. Тухайн жилийн математик болон гадаад хэлний хичээлийн элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноогоороо аймагтаа хамгийн өндөр оноо авсан эхний 10 сурагчид хамаарах оноотой байна;

3.3.2.3.Элсэлтийн ерөнхий шалгалтад гадаад хэл (англи) болон математикийн хичээлээр авсан онооны дунджаар аймагтаа тэргүүлэн хамгийн өндөр оноо авсан эхний 10 сурагчид хамаарах оноотой байна



3.3.2.4 Гадаад хэлний хичээлийн элсэлтийн ерөнхий шалгалтын оноог тооцохдоо хэрвээ тухайн иргэн англи хэл, орос хэлний элсэлтийн ерөнхий шалгалтыг зэрэг өгсөн тохиолдолд өндөр оноо авсан хичээлээр тооцно.

3.4. Бакалавр, магистр, докторын болон богино хугацааны мэргэжлийн сургалтын тэтгэлэгт хамрагдах иргэнд дараахь ерөнхий шаардлага тавигдана:

3.4.1. Холбогдох мэргэжлийн дагуу Флиндерсийн Их Сургуулийн англи хэлний шаардлагыг хангасан байх

3.4.2 Тэтгэлэгт хамрагдах иргэн нь сүүлийн 3-аас доошгүй жил орон нутагт ажиллаж, амьдарч байгаа Өмнөговь аймгийн үндсэн харьяалалтай иргэн байна.

3.4.3. Сургалтын нийт төлбөрийн 25 хувийн Флиндерсийн их сургууль, аймгийн Засаг даргын Тамгын газраас 50 хувийн тэтгэлгийн олгох бөгөөд сургалтын төлбөрийн үлдэгдэл 25 хувийг тухайн иргэн өөрөө хариуцахыг зөвшөөрөх

3.4.4 Энэхүү тэтгэлэг нь зөвхөн тухайн суралцаж буй мэргэжлийн сургалтын төлбөрт олгогдох бөгөөд амьжиргааны зардал, байрны түрээс болон бусад зардлыг тухайн оюутан өөрөө хариуцахыг зөвшөөрөх

3.4.5 Тэтгэлэгт хамрагдах мэргэжлийн чиглэлийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулан 3.4.4-т заасан зардалд Өмнөговь аймгаас дэмжлэг үзүүлэх эсэхийг сонгон шалгаруулалтын ажлын хэсэг шийдвэрлэнэ.

3.4.6 Тэтгэлэгт хамрагдсан иргэнтэй аймгийн Засаг даргын Тамгын газраас гэрээ байгуулах бөгөөд төгсөж ирээд гэрээний дагуу орон нутагтаа 5-аас доошгүй жил ажиллах үүрэг хүлээнэ.

Дөрөв. Тэтгэлгийн сонгон шалгаруулалт

4.1. Тэтгэлэгт хамрагдах иргэнийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг зохион байгуулах бөгөөд Нийгмийн бодлогын хэлтэс тэтгэлгийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангана.

4.2. Ажлын хэсгийн нийт гишүүдийн саналд үндэслэн сонгон шалгаруулалтын удирдамжийг аймгийн Засаг дарга батлах бөгөөд удирдамжийн дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулна. Ажлын хэсгийн хурлын тэмдэглэл, шийдвэрийг үндэслэн тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах оюутныг шалгаруулна.



4.3.Тэтгэлэгт хамрагдах хүсэлтэй иргэн энэ журмын 3-т заасан шаардлагыг хангасан эсэхийг нотлох бичиг баримтыг бүрдүүлэн Боловсролын Газарт хүргүүлнэ.

4.4.Тэтгэлгийн зарыг сонгон шалгаруулалт зохион байгуулахаас 30 хоногийн өмнө Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газрын албан ёсны цахим хуудас болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй, ил тод зарлана.

Тав.Тэтгэлэг олгох

5.1.Суралцагчийн суралцах мэргэжил, тэтгэлгийн төрлийг мэргэжлийн хуваарилалтын дагуу элсэлтийн ерөнхий шалгалтын оноо , бэлтгэл хөтөлбөрийн сурлагын амжилт, ярилцлага, нэмэлт шалгалтын дүнгээр эрэмбэлсний дагуу хуваарилна.

5.2.Тэтгэлгийн сонгон шалгаруулалтад тэнцсэн, 5.1-д заасан мэргэжил, тэтгэлгийн төрлөөр энэ журмын шаардлагыг ханган урилга хүлээн авсан суралцагчид тэтгэлэг олгоно.

5.3.Энэ журмын 2.1.1, 2.1.3-т заасан тэтгэлгийг жил бүр шаардлага хангасан иргэнд олгоно. Бэлтгэл хөтөлбөрт хамрагдсан бусад суралцагчийг санамж бичгийн дагуу жил бүр тэтгэлэгт хөтөлбөрт хамруулна.

Зургаа.Тэтгэлгийн санхүүжилтийн эх үүсвэр

6.1.Тэтгэлэг нь дор дурдсан санхүүжилтийн эх үүсвэрээс бүрдэнэ:

6.1.1.Орон нутгийн төсөв;

6.1.2.Бусад төсөл хөтөлбөрийн зардал.

Долоо.Тэтгэлэгт хамрагдах суралцагчийн эрх, үүрэг

7.1.Тэтгэлгийн сонгон шалгаруулалтад тэнцсэн суралцагч, Өмнөговь аймгийн Засаг дарга, Боловсролын газрын дарга нар гурвалсан гэрээ байгуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана .

7.2.Сонгон шалгаруулалтад тэнцэж тэтгэлэгт хамрагдсан иргэн эрүүл мэндийн шалтгаанаас бусад асуудлаар суралцаагүй тохиолдолд төрөөс санхүүжүүлсэн санхүүжилтийг төрд буцааж бүрэн төлнө. Эрүүл мэндийн шалтгаанаар суралцах боломжгүй болсныг эрүүл мэндийн эрх бүхий байгууллагын тодорхойлолт, дүгнэлтээр нотолсон байна.



7.3. Тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан иргэн энэ журмын 1.3-т заасан хуваарилалтад заасан мэргэжлээр суралцан төгсөөд мөн журмын 7.1-д заасан гэрээний дагуу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид 5 ба түүнээс дээш жил ажиллана.

7.4 Тэтгэлэгт хамрагдсан иргэн гэрээний үүргээ зөрчиж орон нутагт 5 жил ажиллаагүй тохиолдолд гарсан зардлыг 100 хувь буцаан төлнө.

Найм.Бусад

8.1. Сонгон шалгаруулах үйл ажиллагааг суралцагчийн ирүүлсэн баримт бичигт үндэслэн шалгах бөгөөд баримт бичгийн бүрдүүлэлт дутуу, хугацаандаа бүртгүүлээгүй тохиолдолд тухайн иргэнийг сонгон шалгаруулалтад оролцуулахгүй.

8.2 Сонгон шалгаруулалтад тэнцсэн оюутан нь сургалтын төлбөрийн 25 хувийг Төрийн санд тушааж төлбөр төлөгдсөнөөр Флиндерсийн их сургуулиас сургалтад хамрагдах урилга ирнэ.

8.3. Тэтгэлэгтэй холбогдуулж баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн, суралцагчийн мэдээллийг буруу гаргасан буюу сурлагын үнэлгээг бодитой бус үнэлсэн нь тогтоогдвол буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

8.4. Сонгон шалгаруулалттай холбогдон гарсан маргааныг энэ журмын 4.1-т заасан Ажлын хэсэг шийдвэрлэнэ.

8.5. Энэ журам нь Өмнөговь аймгийн үндсэн харьяалалтай иргэнээс бусад иргэдэд хамаарахгүй.

-оОо-